

*Өэдэв: Санжцүгийн залилах  
гэлт хэргээс ээршйлъе*

Нийслэлийн 153-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Энхгэрэл

Наран жаргах тэр л үед бумбатын тайга нам жим, амар амгалан. Байгалийн өнгө нь хүртэл амраач гэх шиг тайвшруулна. Тэртээх алсаас бараа нь үл харагдах аав минь даллаж төсөөллийн ертөнцөөс минь газарт татах хүч шиг буулгасан юм. Аав маань хажууд ирж суугаад хүнхэр хоолойгоор “охин минь хүсээд байсан сургуульдаа орохоор болсон шүү” гэж хэлэхэд хөөр баяслаа дарж чадахгүй би хорвоо дэлхийг донсолготол нь дэвхцэж билээ. Миний аав их алсын ухаантай, сар бүр цалингаасаа тодорхой хувийг нь намайг өөр сургуульд сурахыг хүссэнийг мэдээд хуримтлуулсан гэж гэрийнхэндээ, найзууддаа гайхуулан ярих балчир үеийн минь яриа, сургуульдаа орохыг тэсэн ядан хүлээсэн гуравхан сарын хэрнээ гурван жил мэт тэр л догдлол саяхан мэт санагдана. Ингээд хичээлийн эхний өдөр үсээ чартайтал нь боож, хувцсаа цэмцийтэл өмссөн, хүлээлт дүүрэн охин аавынхаа гарнаас чанга гэгч нь хөтлөөд явж билээ. Ингээд нээлт ч болж, багш нар нь зургаадугаар ангийн нэрсийг дуудтал минийх байсангүй. Алдаа гарчихав уу? гэсэн харцаар аав руугаа ширтэхэд аав маань ч гайхсан харцтай хий л сургуулийн үүд рүү ширтэнэ. Тэгээд захиралтай нь ороод уулзахад, манай сургуульд ийм нэртэй хүүхэд бүртгэлгүй байна гэж хэлээд хэнэгчгүй хаалгаа хааж билээ. Яг энэ л үед аав маань “Санхүүгийн залилах гэмт хэрэгт” өртсөнөө мэдсэн юм. Уурлах, уйлахын дунд гацсан надад хий аав руугаа харц шидэхээс өөр хийж чадах зүйл байсангүй. Ээж аавд уурлан болсон бүх явдлын талаар асуусан юм. Харин аав маань цахимд тавигдсан худал мэдээлэлд итгэн мөнгөө залилуулсан байж таарсан юм. Тэр ч бүү хэл залилсан этгээд нь аавын маань таньдаг хүн нь байсан. Миний аав хэтэрхий сайхан сэтгэлтэй хүн болоод ч тэрүү, найзыгаа цагдаад мэдүүлэхийг хүсээгүй. Үүнээс болоод гэр бүл дотор маш их маргаан гарч, харин миний хувьд аавыг тэр хүнтэй учраа олсон эсэхийг одоо болтол мэддэггүй, асуухыг ч зүрхэлдэггүй юм.

Гурван сар хүлээсэн хүлээлт хормын төдийд нурах тэр л мэдрэмж хэн хүнд таалагдахгүй л байх, гэхдээ бүхэл бүтэн жил хадгалсан мөнгөө найздаа залилуулсан аавд минь бүр л хэцүү байсан нь дамжиггүй. Үүнийг нь ухааралгүй хайрт аав руугаа харц шидэж, уурлаж байснаа бодохоор одоо ч өөртөө бухимдаж, шаналж суудаг юм. Авилгал хээл хахууль, залилан гээд хүн гэдэг амьтан амархан аргаар олох мөнгөний төлөө бүхнээ золиослоход бэлэн болжээ гэлтэй. Миний туулж өнгөрүүлсэн замаар харахад санхүүгийн залиланг таны танил, дотны найз гээд хэн ч итгэлийг тань ашиглан эсвэл өөрөө ч мэдэлгүйгээр үйлдэж болно. Дэлгүүрээс юм худалдан авах, мөнгө шилжүүлэх, гуйвуулга хийх, зээл авах, түрээс төлөх гээд бид өдөр бүр санхүүгийн харилцаанд ордог. Санхүүгийн харилцаа бидний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Гэвч энэ хэрээр санхүү, мөнгөтэй холбоотой залилан, луйврын гэмт хэргийн тоо зогсолтгүй нэмэгдсээр байна.

Хүн төрөлхтөн түүхийнхээ туршид хуурч мэхэлж, итгэл эвдэх аргаар нэг нэгнээ залилж ирсэн боловч “fraud” гэх үг дөнгөж 14 дүгээр зууны үеэс англи хэлэнд нэвтэрч 17 дугаар зууны сүүл үеэс хуулинд тусгагдсан байдаг. Залилан мэхлэх гэмт хэрэг нь хүний бодитоо болон санаатай үйлдлээр хийгддэг бөгөөд энэ нь эрүүгийн хууль зааснаар бусдыг төөрөгдөлд оруулж, урьд олж авсан итгэлийг урвуулан ашиглаж, хуурч мэхлэн бусдын эд хөрөнгө болон эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрхийг өөртөө шилжүүлэн авдаг. Мөн аливаа иргэний өмчлөл эзэмшилд байгаа мөнгө, эд зүйлийг авахын тулд биелэх боломжгүй зүйлийг боломжтой мэтээр итгүүлэх, байхгүй зүйлийг байгаа мэтээр төөрөгдөлд оруулах үйлдлийг залилах гэмт хэрэг гэж энгийн байдлаар тайлбарлаж болно.

Жилээс жилд цахим хэрэглээ өсч өсвөр насны 92,7% нь, нийт хүн амын 80 гаруй хувь нь цахим хэрэглээг идэвхтэй ашигладаг болжээ. Үүний цаана амар хялбар аргаар их хэмжээний мөнгө олох хүсэлтэй хүмүүс залилан хийж байдаг. Үүний нэг жишээ нь “Та гүнж байсан бол ямар гүнж байх байсан бэ?” гэх мэтээр хүний сонирхол татахуйц пост оруулан түүнийг сонирхон орсон хүнээс дахин фэйсбүүктээ нэвтрэх хуудас гаргаж өгдөг, үүнд кодоо хийн орсон тохиолдолд тухайн хүн өөрийн нууц үг, хувийн мэдээллээ алддаг. Ийнхүү тэдгээр залилан хийгч этгээдүүд тантай хамгийн их харьцдаг дотны хүн, найз нөхөд, гэр бүлийн гишүүн рүү тань мөнгө зээлээч гэх нэрийн доор залилан хийдэг байна. Энэхүү төрлийн залилан нь 8 жилийн хорих ялтай бөгөөд үүнд ихэвчлэн олны танил хүн, фэйсбүүк идэвхитэй хэрэглэгч нар хохирч үлддэг. Үүнээс гадна зуучлал, аялал, гадаадад сургана гэх нэрийдлийн доор залилан өргөжиж залуу үеийг хохироож байна.

Хэрвээ та ахан дүүс, амраг саднаасаа асуухын бол тэдний нэг нь заавалчгүй сүлжээний хохирогч болсон, сүлжээнд элсэн орох урилга авсан хүмүүс байдаг. Тэгэхээр сүлжээний залилан гэх гэмт хэрэг буурай орнуудад өргөн тархсан бөгөөд пирамид шинжтэй залилан. Ийм төрлийн залилан нь Монгол улсад 1972 оноос газар авсан ба санхүүгийн пирамид нь сүлжээний маркетинг дээр суурилдаг бөгөөд мөнгө олохын тулд оролцогчдоос шинэ гишүүн элсүүлэхийг шаарддаг. Харин понзи схем нь хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ гэж танилцуулдаг тул оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж нь хууль ёсны ашиг мэт ойлгогддог. Өөрөөр хэлбэл, хэн нэгэнд ашиг өгөхийн тулд өөр нэгнээс мөнгийг нь авч, дахин хөрөнгө оруулалт хийхийг ятгаж, олон хүн хамруулдгаараа ялгаатай. Гэхдээ санхүүгийн луйвар байнга хувьсан өөрчлөгдөж, үйлдлээ өнгөлөн далдалж багаас эхлэн аажим томордог учраас илрүүлэхэд хэцүү, цаг хугацаа ч их шаардагддаг. Энэхүү пирамид нь сүүлд элсэн орсон хүмүүс доороо элсүүлэх хүн олохоо больсон цагт ганхан нурдаг бөгөөд нэлээдгүй хэл ам болж

мартагдсаны дараа буюу дахин гурван жилийн дараа шинэ сүлжээ болон гарч ирэх замаар одоогийн байдлаар нийтдээ 800 гаруй сүлжээ бий болж, сүүлийн 3 жилд 40'000 гаруй иргэн хохирсон байна.

Хууль эрх зүйн хувьд 2001 онд аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хуулийн 8.1.4-т “олон шатлалт маркетингийн буюу пирамид тогтолцооны замаар үйл ажиллагаа явуулах нь хориглосон заалттай” байдаг. Үүнийг 2017.07.01-ний өдөр мөрдөгдөж эхэлсэн эрүүгийн хуулийн 17.3.2.3 дээр “олон шатлалт маркетинг болон пирамид тогтолцооны замаар үйл ажиллагаа явуулсан бол залилангийн гэмт хэрэгт тооцно” хэмээн чангаруулж оруулж ирсэн. Нэг ёсондоо Монгол улс сүлжээний бизнесийн үйл ажиллагааг хуулиар хориглосон байдаг байна. Гэвч хүмүүсийн хууртаад байгаа гол шалтгаан нь цахим зар сурталчилгаа. Худал үгийг мянга хэлбэл үнэн болдог гэдэг шиг эрүүл мэндэд маш сайн нөлөөтэй мэтээр бараа бүтээгдэхүүнээ сурталчлах нь ихэсч, тухайн зарыг олон хүн оруулсны дүнд үнэн мэт санагдан хууртаж сүлжээний бизнесийн хохирогч болдог. Гэвч ДЭМБ аливаа өвчнийг эдгээж анагаах гэж сурталчлах, анагаах ухааны дүгнэлт гаргахыг хориглосон байдаг төдийгүй Монголд ч энэ хууль хэрэгждэг. Сүлжээний компаниудад сайн гэж яригдаад байгаа бүтээгдэхүүнүүд нь угтаа бол эм эмийн бүтээгдэхүүн бус, биологийн идэвхт хүнсний нэмэлт тэжээл бөгөөд энгийн үгээр эмнээс тусдаа ойлголт бөгөөд хяналтгүй орхигдсон байдаг. Ийм төрлийн залилан хийх нь сүлжээнд элсэгчдээс гадна иргэд цахим хуудаснаас тэр тусмаа фэйсбүүкээс эрүүл мэндийн худал мэдээлэл авч хохирох маш том сөрөг нөлөөтэй.

Өнөөдөр Монголын нийгмийг бүрдүүлэгч гишүүдийн ихэнх нь бэлэнчлэх сэтгэлгээтэй болж, ажилгүй, амар хялбар аргаар мөнгө олъё гэх бодолтой болжээ. Үүнээс болоод бага мөнгөөр өндөр ашиг хүртэх сонирхол нь санхүүгийн залилах гэмт хэргийн тоог нэмэгдүүлж байна. 2018 онд энэ төрлийн гэмт хэргийн тоо 2017 оноос 79,3 хувиар өссөн, 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар 2018 оны мөн үетэй харьцуулахад 19,5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаагаас залилан цаашид ч газар авах болно. Тиймээс иргэд бид санхүүгийн залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй байх нь та болон бидний дотны хүмүүс, үр хүүхэд, үе хойчийг маань хамгаалж, эрсдэлгүй ирээдүйг бүтээх болно. Үүгээр ч зогсохгүй санхүүгийн залилан багассанаар хүмүүний бэлэнчлэх сэтгэлгээ буурч, хөдөлмөрөөрөө мөнгө олох залуус улс орныг ядуурлаас гаргах болно.

Санхүүгийн пирамид залилан хүний бэлэнчлэх сэтгэлгээн дээр тулгуурлан ажилладаг. Тиймээс хамгийн түрүүнд анхаарал хандуулах зүйл бол тухайн үйл ажиллагааг явуулах

зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас олгосон эсэхийг нягталж, шаардлагатай мэдээллүүдийг баталгаажуулсны үндсэн дээр сонголт хийх нь чухал.

Хувийн мэдээллээ өөрийн цахим хуудаст нийтэлсэн тэр цагаас тухайн мэдээлэл таны хувийн мэдээлэл байхаа больж залилан мэхлэгч нарын амттай өгөөш нь болдог. Тиймээс цахимд өөрийн хувийн мэдээллээ хэмжүүртэй нийтэлж, өөрийн хэрэглэдэг цахим банк, и-мэйл, твиттер, инстаграм зэрэг бүхий л кодоор нэвтрэх боломжтой хаягууддаа тус бүрт нь өөр өөр код хийх нь залиланд өртөх магадлалыг тань 50%-р бууруулна. Үүнээс гадна цахим тэр тусмаа фэйсбүүкт орж байгаа эрүүл мэндийн 10 мэдээллийн 8 нь худал байдаг гэх судалгаа байдаг. Тиймээс баталгаатай мэдээллийн эх сурвалжийг дагах нь зүйтэй юм. Цахим гэмт хэргийн хохирогч болохоос өөрөө урьдчилан сэргийлэх нь чухал юм.

Иргэдийн оролцоо, эрх зүй, санхүүгийн талаарх мэдлэг хомс байгаа нь санхүүгийн залилангийн гэмт хэрэгт хохирогч болох, мэдэлгүйгээр гэмт хэргийн хамсаатан нь болох аюултай тул энэхүү тал дээр иргэдэд боловсрол олгох зайлшгүй шаардлагатай. Тэр битгий хэл залиланд хохирсон иргэд хүртэл тэрүүхэн тэндээ цагдаад мэдэгдэлгүй өнгөрөөж тухайн залиланг улам газар авахуулдаг. Хэрэв та санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болсон бол санаа зовох хэрэггүй. Энэ тухайгаа холбогдох газар мэдээлэх хэрэгтэй. Ийнхүү мэдээлснээр, та өөрийнхөө хохирлыг бүрэн, эсвэл зарим хэсгийг эргүүлэн олж авах болон бусад хүмүүсийг ижил төрлийн санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд тусална. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд залуу үеийг уриалах хэрэгтэй.

Гэмт хэргийн хохирогч болж, эд материал, сэтгэл санаагаар хохирохоосоо өмнө эхлээд судалгаагаар сайн хийж, хуулийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж зөвлөгөөтэй сайтар танилцаж, тэднээс зөвлөгөө авсны дараа өөрийн үйлдлийг хариуцлагатай хийх нь энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой. Бүх юмыг сайн гүнзгий нягтал, нягтлах тусам бодит үнэн өөрөө илрэх болно. Мөн далайд дусал нэмэр гэгчээр бусдад нөлөөлж далайн давлагааг цунами болго. Иргэн бүр өөрсдийн зорилго, мөрөөдөл, алсын хараагаараа эх орныхоо ирээдүйн хөгжлийн утга учрыг эргэцүүлэн бодож, өөрсдийн зорилгоо бидний гэх ирээдүй рүү чиглүүлэн хөгжил өөд хамтдаа алхацгаая.

## Ном зүй

1. <https://www.montsame.mn/mn/read/243982> нийтлэлийн хэсгээс, УБ., 2018
2. [https://en.wikipedia.org/wiki/Oprah\\_Winfrey](https://en.wikipedia.org/wiki/Oprah_Winfrey) шинэчилсэн нийтлэлийн хэсгээс, АНУ., 2020
3. <https://www.legalinfo.mn/law/details/11634> хуулийн заалтын хэсгээс, УБ., 2021
4. <https://crc.gov.mn/k/31w> судалгааны хэсгээс, УБ., 2020
5. <https://www.youtube.com/watch?v=K1j60OC12hE> Сүлжээний бизнес залилан мөнүү... ярилцлагын хэсгээс, УБ., 2020